# "Органик хүнс" хятад тараг савлав уу

"НИЙГМИЙН ТОЛЬ"

2013-06-18 08:33 GMT+8

Like Share 3 Tweet 2

Нүүдэлчин Монгол түмний эртнээс уламжлагдаж ирсэн хуруу дарам цөөн хоолны нэг нь тараг. Тараг амьд хоол. Махгүй болсон тохиолдолд тарагаар өл залгаад хэдэн сар ч байж чаддаг нь монголчууд.

Тиймээс л энэ төрлийн идээг өнөөдрийг хүртэл боловсруулан хэрэглээнээс халаагүй. Манай улсын нөөцийн найман нэрийн бараанд багтдаг амин дэмээр баялаг энэ хүнсийг өдгөө харийн технологиор хийж байна гэх шүүмжлэл энэ асуудлыг хөндөхөд хүргэв.

Өргөн хэрэглээний бараа материалын 80 гаруй хувийг урд хөршөөс авдаг манай улс өдгөө үндэснийхээ цагаан идээг ч өөрсдийн гараар хийж чадахаа байжээ. Үүний жишээ нь Хятадаас орж ирж буй үй түмэн чанаргүй хүнсний бүтээгдэхүүний нэг нь цагаан дээр хараар “Монгол” гэж бичсэн урд хөршийн тараг. Бидний бяцхан




үрсээр сурталчилгаа хийж, “гого” гэж дуулан олноо танигдсан, гаднаа гяланцаг дотроо паланцаг “Оргил хүнс” компанийн “Гоё” тарагийг дагасан асуудал анхаарал татаад болдоггүй.

Учир нь энэ компани жишээ, жишээний дээд болж, зөрчилтэй компаниудын тэргүүн эгнээнд жагсаад байгааг учир мэдэх нэгэн хэлж буй. Тус компани Монгол түмний уламжлалт идээ болох тарагийг хоол амталж байгаа юм шиг амтлаад хадгалалтын хугацааг зориуд өөрчилж худалдаж байна гэв.

Энэ мэдээлэлтэй зэрэгцэн нэгэн асуултыг уншигч авхай таниас асууя. Би хөдөө төрж эмээгийнхээ бүрсэн тарагийг идэж өссөн тийм л нэгэн жирийн иргэн. Тэгвэл монгол амтыг санаж буй танд сануулахад, жинхэнэ ориг монгол тарагийг даруй идэхгүй бол нэг хоногийн дотор исэж гашуурдаг даа.

Гэтэл “Гоё” гэх энэ тараг ид шидтэй гэмээр гурван сар хадгалах хугацаатай байх юм. Энэ нь 90 хоног хадгалаад ч гашуурч, исэхгүй гэсэн үг. Гэтэл Монгол үнээний тараг хэдхэн цагт л исч сагадаг байтал, “Гоё” тараг ийнхүү нэг л амтаараа гурван сар болно гээд байгаагийн учрыг лавламаар байна.

Энэ юу гэсэн үг вэ, хоол хүнсний эрүүл, аюулгүй байдлыг хянаж байдаг салбарын байцаагчид аа. Хаана байна вэ, хүнсний аюулгүй байдал хэмээн ярьж хааяахан зурагтаар шоуддаг хэсэг нөхөд өө. Одоо л та нөхдийн хяналт, шалгалт хэрэгтэй байна. Учир нь барбарис чихэрнээс жоом, компотноос өт, талхнаас лент, “Гоё” жүүснээс хөгц гээд л юу, юу гэнэ вэ шинэ өглөө бүр шинэхэн аюул сонсогдох нь хэвшил болж, энэхүү сэтгэл сэрдхийлгэм мэдээнд бид дасах шинжтэй.

Ёстой л өнөөх тэнэгийн дотор уужуу гэгчээр Монголчууд бид “Гоё” хэмээх энэхүү тарагийг олон хууль зөрчсөн, шаардлага хангахагүй, Хятадад үйлдвэрлэдэг гэдгийг мэдсэн хэрнээ л “Тийм гэнэ лээ” гээд л уусаар байна. Андуураагүй бол Эрээнд яг ийм амттай тараг идсэнээ тухайн үед гайхширч байснаа дурдъя.

Арай манайх урдаас “Гоё”-ийг оруулж ирдэг юм биш биз гэх хар төрөөд болдоггүй ээ. Хэнбугай ч хэлнэ дээ, Эрээний захын дэлгүүрийн лангуун дээр эрийтэл нь өрчихсөн байдгийг. Үүнийг шалгамаар байна. Хяналтгүй урд хөршөөс угшилтай тараг манай хүнсний зах зээлд хэдийнэ ганхашгүй байр эзэлж өөрийн гэсэн худалдан авагчтай болсон нь сэтгэл эвгүйцүүлнэ. “Гоё”-ийн хэрэглэгчдийн ихэнх хувийг хүүхэд, багачууд эзэлж байгаа нь санаа зовоож буй шалтгаан энэ юм.

Монгол Улсын “Эсэг цагаан идээ, техникийн шаардлага” MNS 4229:2011 стандартыг 2011 оны арванхоёрдугаар сарын 16-ны өдрөөс мөрдөж эхэлсэн. Гэтэл “Гоё” тараг нь 2009 оноос хойш стандарт зөрчсөн, одоо ч зөрчиж буй гол бүтээгдэхүүн аж. Үүнийг мэргэжлийн хяналтынхан дутуу хянаж, худалдан борлуулах дүгнэлт удаа дараа үйлдсэн байх юм.

Өөрөөр хэлбэл, ”Оргил хүнс” компани хууль бус дүгнэлтээр үйл ажилгаагаа явуулсаар өдийг хүрчээ. МХЕГ-ын байцаагчийн дүгнэлт үнэн эсэх нь эргэлзээтэй. Учир нь 2012 оны нэгдүгээр сарын 16, дөрөвдүгээр сарын 19, долдугаар сарын 25-ны өдрийн байцаагчийн дүгнэлтээр шинжилгээ хийгдээгүй байдаг.

Харин 2012 оны аравдугаар сарын 9-ний өдөр Нян судлалын лабораторийн шинжилгээний дүгнэлтээр тараганд байх “Ашигтай бичил биетийн тоо” байх ёстой хэмжээнээс 50 дахин бага гарч, стандартын шаардлага огт хангаагүй гэсэн хариу гарсан байгаа юм. Уг нь стандартын тараганд 1x10-ын долоон зэрэгт байх ёстой аж.

Тэгтэл “Гоё” тарганд асуудал гарч өнөөх хэмжээ 2x10 таван зэрэгт гарчээ. Үүгээр ч дуусаагүй. Уг дүнг дахин баталгаажуулахаар “Хэрэглэгчийн эрх, боловсролын холбоо” дахин өнгөрсөн тавдугаар сарын 23-нд “Оргил хүнс” компанийн үйлдвэрлэж хэрэглэгчдэд хүргэдэг 1.5, 1л, 450 гр, 125 граммын бүтээгдэхүүнээс дээж авч МХЕГ-ын нэгдсэн төв лабораторид шинжлүүлэхэд ашигтай бичил биетийн тоо 100 дахин бага гарчээ.

Энэ олон дүгнэлтийг харахад энэ чинь одоо тараг мөн үү хэмээн асуумаар. "Ориг" тараг исэхгүй, гашуурахгүй байж болдог юм уу. Химийн бодисгүй монгол тарагийг 90 хоног хадгалж үнэхээр болдог эсэхийг “Гоё”-ийн үйлдвэрлэгчдээс асуумаар байна.

Ж.Эрдэнэчимэг

Like Share 3 Tweet 2

АНХААР! Та сэтгэгдэл бичихдээ хууль зүйн болон ёс суртахууныг баримтална уу. Ёс бус сэтгэгдлийг админ устгах эрхтэй. Мэдээний сэтгэгдэлд GoGo.mn хариуцлага хүлээхгүй.

Сэтгэгдлээ энд бичнэ үү

Нэрээ энд бичнэ үү

GO!

**НИЙТ СЭТГЭГДЭЛ 25**

- **зочин** 182.160.18.15
  Дотоодын үйлдвэрлэгчдийг ингэж гүтгэн доромжилохоо одоо зогсоох цаг болсон юм бишүү. Үйлдвэрийг нь, таргаа ямар түүхий эдээр хийдэг, ариун цэврийн ямар нөхцөлд үйлдвэрлэж байгааг нь очиж үзчихээд дараа нь бичих юмаа бичих хэрэгтэй. Энэ бол арай хэрээс хэтэрч байна. Ганц хүн бодит байдлыг гуйвуулж олон удаа бичээд байхаар нийгэмд буруу ойлголтыг газар авахуулж байгаад харамсаж байна. Сүүгээ авч байгаа фермийг нь ч гэсэн очиж үзэх хэрэгтэй. /Хэнтий аймгийн Хэрлэн сумын Өлзийт баг "Атарчандгана сүү" компанийн фермээс сүүгээ авч байгаа/
  2013-06-18 1 0 Хариулах

- **зочин** 182.160.0.215
  тэгвэл зургаар нийтлэл бичээд үзүүлээч. сэтгүүлч нарыг үйлдвэрээрээ аялуулаач. сүүгээ амсуулаач. тэгүүл л итгэнэш д
  2013-06-18 0 0 Хариулах

- **zochin** 202.70.47.99
  haa, erhiig ni jilees iluu hugatsaagaar tsutsal. olson ashgiig ni huraa. odoo uuruur ajillah tsag bolson
  2013-06-18 0 0 Хариулах

- **zochin** 202.70.45.242
  энэ оргил хүнс ххк чинь витафитийн охин компани юм байна лээ шдээ. тэгэхээр энэ сурталчилаад байгаа гоё гэсэн брэнд бүгд генийн өөрчлөлттэй гэсэн үг ш дээ. ингэж мөнгө олоод хэр удаан баян явах юм бол доо хөөрхийй
  2013-06-18 0 0 Хариулах

- **Зочин** 112.72.12.24
  eooe manai mongol uls engseer *** bolhono ee
  2013-06-18 0 0 Хариулах

- **Oyunaa** 202.126.89.180
  sain uu goe targiig awch uudag.hadgalah hugatsaa ni 28 honog gj bn sh dee
  2013-06-18 0 2 Хариулах

- **202.126.89.180** 182.160.0.215
  дээрх 202.126.89.180 гэсэн хаягтай оргил төвийн ажилтан ичээчээ. нэг хаягаас өөртөө оюунаа гэрлээ гэдэг нэр өгөөд ороод байх юм. *** тараг савладгыг чинь хэлчихсэн чинь үхлээ юу.
  2013-06-18 4 0 Хариулах

- **tatlaaa** 202.131.242.253
  kkk uurinhuu haygiig hardaa uhaantan gyai
  2013-06-18 1 0 Хариулах

- **vnen sh de** 202.179.20.165
  hhhee ter oyunaa gerlee gedeg hoyr ner huurhun ym yarhiin. huurhii mu gedgiigni degetsen jin ijsen hvn baavgai *** gdgiig haruulav shiw
  2013-06-24 0 0 Хариулах

- **Gerelee** 202.126.89.180
  монголчуудын зан юм байх да. би хүүхэддээ гоё таргийг авч уулгадаг. зүгээр л байдаг. үйлдвэр нь ханул дүүрэгт байдаг.нэрийн барааныхн дэлгүүрээс авдаг. та нар шинэ үйлдвэрлэсэн тарагнаас нь авдаг юм уу
  2013-06-18 0 3 Хариулах

- **Зочин** 202.72.245.123

тараг биш зүгээр л хоргүй юм уулгаж байгаа болохоор зүгээр л байна шд, хүүхэддээ ядаж тарагны амттай юм авч өгч байгаач
2013-06-18 1 0 Хариулах

- **Зочин** 122.201.18.33
ednii delguurees yum avah hereggui shuu. manaih muudsan undug avch balarsan.
2013-06-18 2 0 Хариулах

- **Зочин** 202.131.235.170
гоё тараг, гоё ундаа бүгд ноотой
2013-06-18 2 0 Хариулах

- **Зочин** 122.201.18.17
хулхи тараг энэ таргыг авч уудаггүй нэг л биш байдаг
2013-06-18 1 0 Хариулах

- **ner** 202.131.242.253
монголчуудын энэ муухай занг одоо яалтай ч билээдээ. тараг хятадаас оруулж ирээд байхдаа яахав дээ. тэнэг хүний толгойд л ийм юм орж ирдэг байх наад тараг чин монгол тарагнаас шал ондоо европ хөрөнгө, технологиор бүрсэн тараг шүүдээ. хүн болгонд сонголт байгаа. монгол аргаар бүрсэн тараг уухуу европ технологиор хийснийг нь хэргэлэхүү гэдэг.
2013-06-18 1 0 Хариулах

- **asuult** 202.131.242.253
ene gaihaad bgaa humuus uildwer deer ni ochood uzeech. uneheer hyatadaas oruulj irj bnuu, mgl-dee uildwerlej bnuu gd?
2013-06-18 4 0 Хариулах

- **Зочин** 202.131.234.106
naad gazraa tgd haagaad torgood hayaldaa ingej ard tumniig hohirooj bolohguishdee
2013-06-18 2 0 Хариулах

- **Зочин** 202.21.113.141
мхг юугаа хийж байнаа
2013-06-18 2 0 Хариулах

- **Зочин** 122.201.18.38
авилгалаа л авна ш тээ. тэд нарын хийдэг ажил нь тэр юм чинь
2013-06-18 5 0 Хариулах

- **нэшигч** 202.9.47.133
би энэ таргийг авч уудаг, сүүлдээ нэг л бишээ, тараг гэхэд тараг биш, ямар ч исгэлэн тарагны амтгүй юм болсон доо. энэ бүтээгдэхүүнийг сайн шалгамаар байна. хятадын бүтээгдэхүүнээр монголчуудаа хулхидаж байгаа энэ компанитай хатуухан үзмээр санагдчихлаа.
2013-06-18 2 0 Хариулах

- **Зочин** 103.10.21.38
тийм шүү. бид ач охиндоо дандаа цөцгийтэй тараг авч өгдөг байгаад нэг удаа байхгүй болохоор нь гоё гэх тарагийг авч өгсөн чинь бөөлжиж хордлого болж үхэхээ шахсан шүү
2013-06-18 1 0 Хариулах

- **Зочин** 122.201.18.163
үндэсний үйлдвэрлэл гэж нэг иймэрхүү хульхи юмнууд байна. дэмжих ч хэрэг байхгүй!!!!!!!!!!!!!!!!!!!!!!!! !!!!!!!!!!!!!!!!!!!!!!!!!!!!!! !!!!!!!!!!!!!!!!!!!!!!!!!!!!!!!
2013-06-18 1 2 Хариулах

- **ayulgui huns** 103.9.88.169
ene met hunsnii ayulgui baidliin tuluu changa zogsoh heregtei. uneheer huuramch, batalgaagui huns zah zeeld niiluuljiigaa bol shuud haalgii ni baridag bolyo
2013-06-18 6 0 Хариулах

- **Зочин** 202.170.67.242
борлуулсан, борлуулахаар бэлдсэн зөрчилтэй барааны үнийн дүнг 10 нугалж торгууль тавьдаг болмоор байна.
2013-06-18 4 0 Хариулах

- **asuult** 49.0.200.171
  hotiin a zeregleliin bused tov zam daguu uilchelgee yvuulhad tohiromjtoi 1 davhariin 70m2 ajiliin bair zarna 99119709
  2013-06-18 0 7 Хариулах

# САНАЛ БОЛГОХ


Техникийн захуудыг аравдугаар сарын 1-ний дотор хотын төвөөс нүүлгэнэ 5 цаг 13 минут 20



Осол гаргасан “Петро Чайна”-г нефтийн хоолойгоор шагнах уу 4 цаг 28 минут 7


Налайх дүүрэгт гахай өвчилж, олноор үхжээ 3 цаг 16 минут 3


Яармагийн гүүрийг Баянзүрхийн товчоотой холбосон замыг наадмаас өмнө ашиглалтад оруулна 2 цаг 56 минут 6



Зам, барилгын бүх мэдээллийг гар утсаараа авах боломжтой боллоо 1 цаг 19 минут 1


50 саяын уналт шинэ дугаар 28 минут



[Шинэ](#) [Их уншсан](#) [Их сэтгэгдэлтэй](#)



Монголын эдийн засгийн чуулганы маргаашийн хөтөлбөр 16 минут



Даргын ширээ, даамлын зангиатай даанч эвлэрээгүй найруулагч 20 минут



З.Энхболд:Энэ жил Асгатын мөнгөний ордыг ашиглалтанд оруулах ажил заавал хийх ёстой 21 минут



50 саяын уналт шинэ дугаар 28 минут




Зам, барилгын бүх мэдээллийг гар утсаараа авах боломжтой боллоо 1 цаг 19 минут 1



Өнгөрсөн 20 жилд Монголын эдийн засаг 10 дахин өсчээ 1 цаг 50 минут 3



Оюутны таеквондогийн улсын аваргыг шалгаруулна 1 цаг 57 минут




[Крым эдийн засгийн онцгой бүс болох уу? 2 цаг 7 минут 1]



[Мексикийн буланд 640 тонн газрын тос асгарчээ 2 цаг 22 минут]



[ХААН Банкны “Кисс” өдөрлөгийн 10 супер азтан шагналаа гардан авлаа 2 цаг 30 минут]



[Ч.Хашчулуун: Занарын хайгуул хийх 20 орчим компани байна 2 цаг 33 минут 2]



[Сагсчид холбоогоо удирдана 2 цаг 41 минут 1]



[Н.Алтанхуяг: Бид хамаг баялгаа үнэтэй машин, чамин утсанд өгчээ 2 цаг 49 минут 24]



[Яармагийн гүүрийг Баянзүрхийн товчоотой холбосон замыг наадмаас өмнө ашиглалтад оруулна 2 цаг 56 минут 6]



[Налайх дүүрэгт гахай өвчилж, олноор үхжээ 3 цаг 16 минут 3]


Цалингийн нэмэгдлийн талаар албан тоот илгээжээ 3 цаг 22 минут 6

Ж.Дэлгэрсайхан: Эдийн засаг сэргэх цаг ойрхон харагдахгүй байна 3 цаг 57 минут 3 1

Г.Балам: 22 хүүхэд төрүүлж төрд цаг наргүй зүтгэхдээ өвдөж, ядарч явсангүй 4 цаг 15 минут 36 9


Осол гаргасан “Петро Чайна”-г нефтийн хоолойгоор шагнах уу 4 цаг 28 минут 7

Дэлхий дээр жилд есөн сая хүн сүрьеэгээр өвчилдөг 4 цаг 37 минут

Орон сууцныхаа ам.метрийг хэмжмээр байна уу 4 цаг 41 минут 6 4

Арга чинь хоцрогдсон байна, улстөрчид өө 4 цаг 57 минут 9 1

Сүүлчийн 25 настнууд 5 цаг 4 минут 26


Техникийн захуудыг аравдугаар сарын 1-ний дотор хотын төвөөс нүүлгэнэ 5 цаг 13 минут 20



“Буянт-Ухаа-1” хорооллын бүртгэл өнөөдөр дуусна 5 цаг 15 минут 5



Нандиагийн ток шоу: Рехтус компанийн ерөнхий захирал В.Ойдов 5 цаг 23 минут



Г.Эрхэмбаяр аварга түрүүлж О.Хангай арслан үзүүрлэв 5 цаг 42 минут 10



Эдийн засгийн форум 2014: Өнөөдрийн хуралдааны хөтөлбөр 5 цаг 48 минут 1



"Монголдоо бүтээе" уриан дор эдийн засгийн чуулган эхэллээ 6 цаг 5 минут 1



Гаалийнхан бэлэн мөнгө авахаа болино 6 цаг 16 минут 4



Маргаашнаас ихэнх нутгаар цас орж бага зэрэг хүйтэрнэ 6 цаг 24 минут



Хоккейчид “Challenge” cup тэмцээнээс хүрэл медаль хүртэв 6 цаг 30 минут


[Бага сургууль цэцэрлэгийг 2,2 тэрбумаар барихаар төсөвлөжээ 6 цаг 38 минут 3]


[Какүрюү М.Ананд мэргэжлийн сүмогийн 71 дэх их аваргын болзол хангалаа өчигдөр 44 22]


[Эмнэлгүүдэд албан бус хураамж төлсөн бол сайдад “ховлоорой” өчигдөр 9]


[Эмнэлгүүд эрэгтэйчүүдийн кабинеттай болно өчигдөр 2]


[Хөвсгөлийн хүн амын 80 гаруй хувь баталгаат ус хэрэглэдэг өчигдөр 2]


[Монгол хүн сансарт ниссэний 33 жилийн ой тохиож байна өчигдөр 9 5]


[Гадаад харилцааны сайдын Австралид хийсэн айчлал өндөрлөлөө өчигдөр]


[Наурызын баяр үргэлжилж байна өчигдөр 6 1]


УИХ-ын дарга казах түмэнд мэндчилгээ дэвшүүлэв уржигдар 1 2

Б.Баярцэнгэл: Лениний хөшөөг буулгахаас нь өмнө амжиж зурсан уржигдар 5

Йог: Бие, сэтгэл, оюуны нэгдэл уржигдар 7 1


Татвар хураах газрын байршлуудыг зарлалаа уржигдар 1 1

Наурызын баярыг Чингисийн талбайд тэмдэглэв уржигдар 83 5

HiTone-д Монгол реппер GEE-ийн шинэ дуунууд нэмэгдлээ уржигдар 2
“Бид” хамтлагийнхан дуулсаар явна уржигдар

Мурат: Наурызаар 40 айл хэссэн хүн тэр жилдээ хийморьтой явдаг уржигдар 24 9

Д.Ганцэцэг: Би дэндүү сайхан хайрыг мэдэрсэн уржигдар 16 4



[Бяцхан хүүгийн дотны найз уржигдар 2 5]

# GO СПОНСОР ЛИНК

**Юнителийн хэрэглэгчид 8 жилийн ойн бэлгээ аваарай**
Юнител групп 8 жилийн ойгоо тохиолдуулан сар бүрийн 8-ны өдөр эрхэм хэрэглэгчиддээ бэлэг барьж байгаа билээ.

**Дэлхийн үйлдвэр Монголд...**
“Айсмарк” дэлхийн №1 зайрмагны тоног төхөөрөмж үйлдвэрлэгч “Текно Айс” компанитай хамтран ажиллахаар...

**Скайтел групп Олон улсын роумингийн цогц үйлчилгээг нэвтрүүллээ**
ОЛОН УЛСЫН РОУМИНГИЙН ЦОГЦ үйлчилгээ болон МЕССЭЖ РОУМИНГ үйлчилгээг ашиглах боломжтой боллоо

## GO КОМИК




# GO ЖИРГЭЭ

**Batjav_Ts** @BatjavTs 24m
Г.Балам: 22 хүүхэд төрүүлж төрд цаг наргүй зүтгэхдээ өвдөж, ядарч явсангүй news.gogo.mn/r/137095 via @www_gogo_mn

**Эгийн голын УЦС** @EGHPPP 43m
Усны зөвлөх инженер Ц.Сосорбарам: Аливаа гүрэн улсуудын хөгжил нь Усны нөөц, түүний ирээдүйн хандлагыг дагаж байдаг news.gogo.mn/r/136645
Retweeted by И.Цэрэнхүү
Expand

**И.Цэрэнхүү** @IshtsedenT 33m
УЦС хиймэл нуурын тухай бидний ечигдерийн мэтгэлцээний хариу гвл эндээс хараад жаахан бодход грна ln.is/news.gogo.mn/r…
przez @www_gogo_mn

gogo
www.mongolcontent.mn
© 2007-2014 Монгол Контент ХХК
Монгол улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, Самбуугийн гудамж 18-1, Марс төв.
Маркетинг, сурталчилгаа: 70110013
Мэдээ, Програм хангамж: 326590
info@mongolcontent.mn
news@mongolcontent.mn
(GoGo мэдээний алба)
Сурталчилгаа байрлуулах